



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/117

Мандалговь

Газар эзэмших эрхийн гэрчилгээний
хугацаа сунгах тухай

Монгол Улсын Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйл 21.4.3, 30 дугаар зүйл 30.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

Нэг. Сайнцагаан сумын 7 дугаар багийн нутаг дэвсгэр (Буяннэмэхийн өргөн чөлөө-4-405)-т байршилтай “Алтан цант” ХХК (РД:2012693)-ний худалдаа үйлчилгээний зориулалттай 2427 м.кв (0,24га) газрын эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг 40 жилээр сунгасугай.

Хоёр. Дээрх газар эзэмшигчтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээнд тэмдэглэл хийхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), мөн гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт, Сайнцагаан сумын Засаг дарга, хотын захирагч (Р.Мөнхтогтох), аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат) нарт үүрэг болгосугай.

Гурав. Эзэмшил газраа байгаль орчинд сөрөг нөлөөгүйгээр зориулалтын дагуу эзэмшиж, газрын төлбөрөө хугацаанд нь төлж байхыг “Алтан цант” ХХК-ний захирал (Б.Солонго)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

482010326